

## Агуулга

|  |       |
|--|-------|
| 1. Аудитын санал дүгнэлт.....  | 2-3   |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....                                  | 5     |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                         | 4     |
| 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....                         | 5     |
| 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....                          | 6     |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....                           | 7     |
| 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....     | 8     |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....                                 | 9     |
| 3.1 Байгууллагын үйл ажилагаа .....                                      | 9     |
| 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....           | 9     |
| 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....                                | 10-12 |
| 4. Аудитын тайлан .....  | 13    |
| 4.1 Ерөнхий зүйл .....   | 13    |
| 4.2 Дотоод хяналт .....  | 13    |
| 4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....                          | 13    |
| 4.4 Материаллаг байдал.....  | 14    |
| 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 12    |
| 5.1 Шилэн дансны мэдээлэл.....   | 12    |
| 6. Завсрынаудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....               | 13    |
| 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....                              | 13    |
| 8. Аудитын илрүүлэлт.....  | 13    |
| 8.1 Залруулсан алдаа .....   | 13    |
| 8.2 Төлбөрийн акт .....  | 13    |
| 8.3 Албан шаардлага .....  | 14    |
| 8.4 Зөвлөмж.....   | 15    |

**Товчилсонүгийнжагсаалт**

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

СТОУС Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

ТЭЗҮ Техник эдийн засгийн үзүүлэлт

ТУЗ Төлөөлөн удирдах зөвлөл

ТБОНӨТХ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

НАНБХАСЗАСЗУСНийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах,  
ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.15 № 01/275  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОГОЙН ГОЛ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТХҮҮ ТАНАА

### Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Могойн гол ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Могойн гол ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилон ажиллуулж чадаагүйгээс тус компанийн удирдлагын үйл ажиллагаа алдагдсан байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.6 дахь заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 193.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба эдгээр нь бүх данстад тархсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.6, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн ба Оршин байх, Иж бүрэн байх, Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
- Үйл ажиллагааны зардалтай холбоотой 460.1 сая төгрөгийн зөрчил гаргаж зардлыг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 13.7, 20.1.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.1.5, 15.2.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн ба Эрх ба үүрэг, Нийцсэн бөгөөд зохистой, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Могойн гол ХК нь төлөвлөгөөгөөр 1200 м3 хөрс хуулалт хийж, 135 мян.тн нүүрс борлуулж, 173.2 сая төгрөгийн ашигтай ажиллагааг төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 764.1 м3 хөрс хуулалт хийж, 130.3 мян.тн нүүрс борлуулж 1,359.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

### Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 193.6 сая төгрөгийн алдааг залруулж, 40.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 193.2 сая

төгрөгийн зөрчлийг таслан зогоох албан шаардлага өгч, 3,002.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

#### **Бусад асуудлын хэсэг**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хуралдаанууд хойшилсноос Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудалд маргаан үүссэнээс Төлөөлөн удирдах зөвлөл бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

| Мөрийн дугаар | Балансын зүйл                         | Үлдэгдэл                |                         |
|---------------|---------------------------------------|-------------------------|-------------------------|
|               |                                       | 1 сарын 1               | 12 сарын 31             |
| 1.1.01        | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө       | 1,033,161,273.91        | 455,965,933.98          |
| 1.1.02        | Дансны авлага                         | 143,156,855.18          | 85,538,927.42           |
| 1.1.03        | Татвар, НДШ-ийн авлага                | 0.00                    | 16,539,696.59           |
| 1.1.04        | Бусад авлага                          | 5,244,932.00            | 3,098,709.17            |
| 1.1.06        | Бараа материал                        | 3,833,831,706.66        | 4,421,432,561.89        |
| 1.1.07        | Урьдчилж төлсөн зардал/тооцоо         | 76,419,820.00           | 382,597,400.00          |
| 1.1.08        | Бусад эргэлтийн хөрөнгө               | 27,055,760.27           | 26,511,264.78           |
| 1.1.11        | Эргэлтийн хөрөнгийн дүн               | 5,118,870,348.02        | 5,391,684,493.83        |
| 1.2.01        | Үндсэн хөрөнгө                        | 1,437,360,234.91        | 1,377,386,614.89        |
| 1.2.02        | Биет бус хөрөнгө                      | 157,866,800.00          | 225,284,475.76          |
| 1.2.10        | Эргэлтийн бус хөрөнгийн дүн           | 1,595,227,034.91        | 1,602,671,090.65        |
| 1.3           | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>             | <b>6,714,097,382.93</b> | <b>6,994,355,584.48</b> |
| 2.1.1.01      | Дансны өглөг                          | 60,834,622.42           | 72,639,046.33           |
| 2.1.1.03      | Татварын өр                           | 405,878,014.05          | 45,499,054.77           |
| 2.1.1.08      | Урьдчилж орсон орлого                 | 886,375,948.25          | 794,453,452.25          |
| 2.1.1.10      | Бусад богино хугацаат өр төлбөр       | 2,123,231.00            | 28,070,000.00           |
| 2.1.1.13      | Богино хугацаат өр төлбөрийн дүн      | 1,355,211,815.72        | 940,661,553.35          |
| 2.1.2.04      | Бусад урт хугацаат өр төлбөр          | 793,230,990.80          | 793,230,990.80          |
| 2.1.2.06      | Урт хугацаат өр төлбөрийн дүн         | 793,230,990.80          | 793,230,990.80          |
| 2.2           | <b>Өр төлбөрийн нийт дүн</b>          | <b>2,148,442,806.52</b> | <b>1,733,892,544.15</b> |
| 2.3           | Эздийн өмч                            | 0.00                    | 0.00                    |
| 2.3.01        | Өмч: - төрийн                         | 42,310,722.00           | 42,310,722.00           |
| 2.3.02        | - хувийн                              | 40,651,478.00           | 40,651,478.00           |
| 2.3.03        | - хувьцаат                            | 0.00                    | 0.00                    |
| 2.3.06        | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл   | 1,375,789,181.23        | 1,375,789,181.23        |
| 2.3.08        | Эздийн өмчийн бусад хэсэг             | 202,833,326.81          | 202,833,326.81          |
| 2.3.09        | Хуримтлагдсан ашиг                    | 2,904,069,868.37        | 3,598,878,332.29        |
| 2.3.09.1      | Тайлангийн үеийн ашиг                 | 0.00                    | 1,217,179,530.92        |
| 2.3.09.2      | Өмнөх үеийн ашиг                      | 2,904,069,868.37        | 2,381,698,801.37        |
| 2.3.11        | Эздийн өмчийн дүн                     | 4,565,654,576.41        | 5,260,463,040.33        |
| 2.4           | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b> | <b>6,714,097,382.93</b> | <b>6,994,355,584.48</b> |

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Балансын зүйл                   | Өмнөх оны дүн    | Тайлант жилийн дүн |
|---------------|---------------------------------|------------------|--------------------|
| 01            | Борлуулалтын орлого (цэвэр)     | 4,690,505,700.94 | 6,987,983,289.16   |
| 02            | Борлуулалтын өртөг              | 3,135,861,347.52 | 4,452,785,460.06   |
| 03            | Нийт ашиг( алдагдал)            | 1,554,644,353.42 | 2,535,197,829.10   |
| 08            | Бусад орлого                    | 52,595,974.89    | 57,113,480.50      |
| 08.1          | Орлогын дүн                     | 52,595,974.89    | 57,113,480.50      |
| 09            | Борлуулалт, маркетингийн зардал | 276,479,335.55   | 433,220,280.48     |
| 10            | Ерөнхий ба удирдлагын зардал    | 324,070,833.81   | 551,033,040.52     |
| 11            | Санхүүгийн зардал               | 0.00             | 0.00               |

|      |   |                |                  |
|------|---|----------------|------------------|
| 12   | Бусад зардал                                | 127,648,653.88 | 248,331,200.63   |
| 12.1 | Зардлын дүн                                 | 728,198,823.24 | 1,232,584,521.63 |
| 17.1 | Олз, гарзын дүн                             | 0.00           | 8,157.50         |
| 18   | Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)       | 879,041,505.07 | 1,359,734,945.47 |
| 19   | Орлогын татварын зардал                     | 98,156,859.01  | 142,555,414.55   |
| 20   | Татварын дараах ашиг (алдагдал)             | 780,884,646.06 | 1,217,179,530.92 |
| 22   | Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)        | 780,884,646.06 | 1,217,179,530.92 |
| 24   | Орлогын нийт дүн                            | 780,884,646.06 | 1,217,179,530.92 |
| 25   | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | 0.00           | 0.00             |

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт   | Өмч          | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн         |
|--|--------------|-------------------------------------|---------------------------|--------------------|------------------|
| <b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>                             | 82,962,200.0 | 1,375,789,181.23                    | 202,833,326.81            | 2,123,185,222.31   | 3,784,769,930.35 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга |              |                                     |                           | 780,884,646.06     | 780,884,646.06   |
| <b>Залруулсан үлдэгдэл</b>   | 82,962,200.0 | 1,375,789,181.23                    | 202,833,326.81            | 2,904,069,868.37   | 4,565,654,576.41 |
| НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга                    |              |                                     |                           | -522,371,067.00    | -522,371,067.00  |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)                                    |              |                                     |                           | 1,217,179,530.92   | 1,217,179,530.92 |
| <b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>                             | 82,962,200.0 | 1,375,789,181.23                    | 202,833,326.81            | 3,598,878,332.29   | 5,260,463,040.33 |

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт  | Өмнөх он         | Тайлант он       |
|---------------|---|------------------|------------------|
| 0             | Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ    | 0.00             | 0.00             |
| 1             | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ                 | 0.00             | 0.00             |
| 1.1           | Мөнгөн орлогын дүн (+)                                | 6,193,871,227.82 | 7,587,253,493.23 |
| 1.1.1         | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого          | 6,026,683,115.82 | 7,477,653,699.98 |
| 1.1.6         | Бусад мөнгөн орлого                                   | 167,188,112.00   | 109,599,793.25   |
| 1.2           | Мөнгөн зарлагын дүн (-)                               | 4,444,675,153.53 | 7,260,981,041.16 |
| 1.2.1         | Ажиллагчдад төлсөн                                    | 869,785,924.00   | 1,229,014,385.00 |
| 1.2.2         | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн                | 317,241,937.27   | 378,572,988.30   |
| 1.2.3         | Бараа материал худалдан авахад төлсөн                 | 912,766,999.00   | 1,466,584,103.06 |
| 1.2.4         | Ашиглалтын зардалд төлсөн                             | 119,322,988.05   | 89,912,100.55    |
| 1.2.5         | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 1,450,198,266.40 | 2,085,833,298.06 |
| 1.2.6         | Хүүгийн төлбөрт төлсөн                                | 11,736,711.50    | 0.00             |
| 1.2.7         | Татварын байгууллагад төлсөн                          | 664,518,291.76   | 1,354,170,175.81 |
| 1.2.8         | Даатгалын төлбөрт төлсөн                              | 4,581,675.00     | 19,848,263.72    |
| 1.2.9         | Бусад мөнгөн зарлага                                  | 94,522,360.55    | 637,045,726.66   |

|       |  |                  |                  |
|-------|--|------------------|------------------|
| 1.3   | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн             | 1,749,196,074.29 | 326,272,452.07   |
| 2.2   | Мөнгөн зарлагын дүн (-)  | 46,049,900.00    | 426,154,550.00   |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                            | 46,049,900.00    | 375,624,970.00   |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                          | 0.00             | 50,529,580.00    |
| 2.3   | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | -46,049,900.00   | -426,154,550.00  |
| 3.2   | Мөнгөн зарлагын дүн (-)  | 816,257,187.41   | 477,313,242.00   |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө                   | 336,257,187.41   | 0.00             |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг   | 480,000,000.00   | 477,313,242.00   |
| 3.3   | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн         | -816,257,187.41  | -477,313,242.00  |
| 4     | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ                                       | 886,888,986.88   | -577,195,339.93  |
| 5     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл               | 146,272,287.03   | 1,033,161,273.91 |
| 6     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл              | 1,033,161,273.91 | 455,965,933.98   |

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

| №  | Үзүүлэлт                                   | Хэмжих нэгж    | 2021 оны гүйцэтгэл | 2022 оны           |                    | Зөрүү              | Хувь         |
|----|--|----------------|--------------------|--------------------|--------------------|--------------------|--------------|
|    |  |                |                    | Төлөвлөгөө         | Гүйцэтгэл          |                    |              |
|    | <b>Нийт орлогын дүн</b>                    | <b>мян.төг</b> | <b>4,743,101.7</b> | <b>6,811,255.0</b> | <b>7,045,104.9</b> | <b>233,846.9</b>   | <b>103,4</b> |
| 1  | Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого | мян.төг        | 4,671,258.1        | 6,751,255.0        | 6,939,602.9        | 188,347.9          | 102.8        |
| 2  | Туслах үйл ажиллагааны борлуулалтын орлого | мян.төг        | 32,702.3           | 20,000.0           | 39,423.0           | 19,423.0           | 197.1        |
| 3  | Үйл ажиллагааны бус орлого                 | мян.төг        | 0.00               | 0.00               | 23,005.5           | 23,005.5           |              |
| 4  | Халаалтын орлого                           | мян.төг        | 39,141.3           | 40,000.0           | 43,073.5           | 3,073.5            | 107.7        |
| 6  | <b>Нийт зардал</b>                         | <b>мян.төг</b> | <b>3,864,060.1</b> | <b>6,638,013.2</b> | <b>5,704,870.0</b> | <b>-933,143.2</b>  | <b>85,9</b>  |
| 7  | Нүүрсний борлуулалтын өртөг                | мян.төг        | 3,033,492.2        | 5,223,511.0        | 4,303,246.8        | -920,264.2         | 82,4         |
| 8  | Борлуулалтын зардал                        | мян.төг        | 276,479.3          | 491,509.6          | 433,220.3          | -58,289.30         | 88.1         |
| 9  | Удирдлагын зардал                          | мян.төг        | 324,070.8          | 574,815.0          | 570,533.0          | -4,982.00          | 99.3         |
| 10 | Туслах үйл ажиллагааны зардал              | мян.төг        | 26,592.0           | 26,000.0           | 29,266.6           | 3,266.60           | 112,6        |
| 11 | Үйл ажиллагааны бус зардал                 | мян.төг        | 127,648.7          | 210,400.0          | 248,331.2          | -37,931.2          | 118.0        |
| 12 | Уурын зуухны зардал                        | мян.төг        | 75,777.1           | 97,777.6           | 108,502.6          | 10,725.00          | 111,0        |
| 13 | Бараа материал борлуулсны өртөг            | Мян.төг        |                    | 14,000.0           | 11,769.5           | -2230,5            | 84,1         |
| 14 | <b>Нийт ашиг</b>                           | <b>мян.төг</b> | <b>879,041.6</b>   | <b>173,241.8</b>   | <b>1,359,734.9</b> | <b>1,166,993.1</b> | <b>773,6</b> |

|    |                           |            |       |         |       |        |       |
|----|---------------------------|------------|-------|---------|-------|--------|-------|
| 15 | Хөрс хуулалт              | мян. м куб | 810.2 | 1,200.0 | 764.1 | -435,9 | 63,7  |
| 16 | Олборлох нүүрсний хэмжээ  | мян.тн     | 90.0  | 115.00  | 150.0 | 35,0   | 130,4 |
| 17 | Борлуулах нүүрсний хэмжээ | мян.тн     | 100.0 | 135.00  | 130.3 | -4,7   | 96,5  |

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Могойн гол ХК-ийн зорилго нь үйл ажиллагаандаа орчин үеийн дэвшилт технологийг нэвтрүүлэн олон улсын чанар стандартад нийцүүлсэн нүүрсийг олборлож, ажилтнуудаа аюулгүй орчинд, сэтгэл хангуулан ажиллаж, өсөж дэвших боломжоо ханган ажиллаж, эдийн засгийн хувьд бие даасан орон нутгийн хөгжлийг тэргүүлэгч компани болоход оршино. Могойн гол ХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол улсад ашигт малтмалын хайгуул, олборлолт хийх болон хэрэв боломжтой гэж үзвэл боловсруулах
- Ашигт малтмалыг боловсруулах, тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдах худалдан авах импортлох, экспортлох зэргээр гадаад дотоод худалдаа эрхлэх
- Монгол улсын хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх

Могойн гол ХК -ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд “хувьцаат компани” гэсэн статустай байна. Өмчийн 51 хувийг Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, 49 хувийг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

Тайлант онд ТУЗ-ийн 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 10 тоот тогтоолоор 2021 оны 497,8 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэр батлан 2022 оны 4 сард Төрийн 51 хувьд ногдох 253,9 сая төгрөг, хувьцаа эзэмшигчдэд ногдох 243,9 сая төгрөгийг шилжүүлсэн байна .

#### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Могойн гол ХК нь 1970 онд Могойн голын уурхай нэрээр анх үүсгэн байгуулагдаж байсан бөгөөд Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1994 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 35 дугаар тогтоолоор хувьцаат компани болгон өөрчилсөн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалттай нийцэж байна.

Могойн гол ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 02 дугаар тогтоолоор 0.8-1.0 сая төгрөгөөр тогтоосон нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13-д “Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай

- Төрийн хэмнэлтийн тухай хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Могойн гол ХК нь 2022 оны 11 сард Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулан мөрдөж байна. UNICUS программыг ашиглан нягтлан бодох бүртгэл тайланг бэлтгэж байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 280,258.2 мянган төгрөг буюу 104.2 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт         |
|---|--------------------|--------------------|------------------|
| Б   | 1                  | 2                  | 3=2-1            |
| Мөнгөн хөрөнгө                                    | 1,033,161.3        | 455,965.9          | -577,195.4       |
| Авлага  | 148,401.8          | 105,177.3          | -43,224.5        |
| Урьдчилж төлсөн тооцоо                            | 76,419.8           | 382,597.4          | 306,177.6        |
| Бараа материал                                    | 3,833,831.7        | 4,421,432.6        | 587,600.9        |
| Бусад эргэлтийн хөрөнгө                           | 27,055.8           | 26,511.3           | -544.5           |
| Үндсэн хөрөнгө                                    | 1,437,360.2        | 1,377,386.6        | -59,973.6        |
| Биет бус хөрөнгө                                  | 157,866.8          | 225,284.5          | 67,417.7         |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>6,714,097.4</b> | <b>6,994,355.6</b> | <b>280,258.2</b> |
| Өр төлбөрийн дүн                                  | 2,148,987.2        | 1,733,892.5        | -415,094.7       |
| Богино хугацаат өглөг                             | 1,355,756.2        | 940,661.6          | -415,094.7       |
| Урт хугацаат өглөг                                | 793,231.0          | 793,231.0          |                  |
| Эздийн өмч  | 4,565,654.6        | 5,260,463.0        | 694,808.4        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>6,714,097.4</b> | <b>6,994,355.6</b> | <b>280,258.2</b> |

Дээрх хүснэгтэд байгаа балансын дансанд орсон өөрчлөлтийг тодруулбал дараах байдалтай байна. Үүнд:

1. Банк дахь мөнгөний үлдэгдэлд Төрийн банк, Хаан банкны харилцах дансанд байгаа 455.9 сая төгрөг байна.
2. Авлагын үлдэгдэл өмнө оноос 43.2 сая төгрөгөөр буурч, 56.3 хувийг борлуулалтын авлага 24.8 хувийг бусад авлага, 18.9 хувийг насжилт өндөртэй авлага тус тус эзэлж байна. Авлага дансанд бүртгэгдсэн 86.2 сая төгрөгийн 77,9 хувийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дах заалтыг зөрчсөн ба хянан иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Тайлант онд урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл 382.6 сая төгрөг байгаа нь 2019 онд Гранд Майнинг Экюпмент ХХК-тай уурхайн өрмийн машин 852.0 сая төгрөгөөр худалдан авахаар гэрээ байгуулж урьдчилгаа 70.0 сая төгрөгийг шилжүүлсэн тооцоог хийгээгүй, тайлант онд түрээсийн гэрээний урьдчилгаанд ТҮАСИА ХХК-д 181.0 сая төгрөг, нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэрийн урьдчилгаа 111.8 сая төгрөг, эмч нарын холбоонд 2023 оны үзлэгийн урьдчилгаа 15.0 сая төгрөг тус тус шилжүүлж өмнөх оноос 306.2 сая төгрөгөөр өссөн байна.
4. Бараа материалын дансны үлдэгдэл 4,421.4 сая төгрөг болж 587.6 сая төгрөгөөр байна. Үүнд нүүрсний үлдэгдэл 949.3 сая төгрөгөөр, бараа материал дансанд тэсрэх материалын үлдэгдэл 176.6 сая төгрөгөөр, хангамжийн материал дансны үлдэгдэл 190.4 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.
5. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,377.4 сая төгрөг болж 59.9 сая төгрөгөөр буурсан байна. Өөрийн хөрөнгө 19.6 сая төгрөгөөр, уурын зуухны тогоо 72.5 сая төгрөгөөр, уурхайн машин механизм 139.1 сая төгрөгөөр капиталжуулж, Нүүрсний лаборатори 62,2 сая төгрөгөөр, 2.5 сая төгрөгийн мотоцикл, 56,3 сая төгрөгийн

- компьютер, техник хэрэгсэл, 34,1 сая төгрөгөөр бусад машин тоног төхөөрөмжөөр худалдан авч тус тус нэмэгдүүлсэн байна.
- 6. Хувьцаа Эзэмшигчдийн хурлын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 04 дугаар тогтоолоор үлдэх өртөггүй, ашиглалтын хугацаа дууссан 31.6 сая төгрөгийн 1 ширхэг Белаз 540-09 маркийн машин, 1 ширхэг Трекс 10 автомашин акталж данснаас хассан байна. Тайлант хугацаанд хуримтлагдсан элэгдэл дансанд 425.8 сая төгрөгийн өөрчлөлт гарсан байна.
- 7. Биет бус хөрөнгө дансанд тайлант онд санхүүгийн болон борлуулалтын программ 27,1 сая төгрөгөөр, НБББББ 19,5 сая төгрөгөөр, Гамшгийн болон байгаль орчны үнэлгээ хийлгэж 34,4 сая төгрөг нийт 81,1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 133,7 сая төгрөгийн хорогдол байгуулж данс бүртгэлд тусгасан байна.
- 8. Дуусаагүй барилга дансны үлдэгдэл 5.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2001 онд ажилчдын халуун усны барилга барьж эхэлсэн боловч цэвдэгтэй газар таарч барилгыг цааш үргэлжлүүлэх боломжгүй болсон байна.
- 9. Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 935.1 сая төгрөгийн өр төлбөр байгаа нь урьдчилж орсон орлого 794.4 сая төгрөг, татварын өглөг 43.5 сая төгрөг, бэлтгэн нийлүүлэгчид өглөг 69.1 сая төгрөг, 2023 онд өндөр насны тэтгэвэрт гарах ахмадын тэтгэмж 28,1 төгрөг байна.
- 10. Урт хугацаат өр төлбөр дансанд 1978 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Засгийн газарт буцаан төлөх гэрээгээр олгосон зээлийн үлдэгдэл 344.2 сая төгрөг, 2001 онд Япон улсын хөрөнгө оруулалтаар 5-н жилийн хугацаатай хүүгүй олгогдсон 449.0 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр байна.
- 11. Эздийн өмч дансны үлдэгдэл төрийн өмч 42.3 сая төгрөг, хувьцаа эзэмшигчдийн өмч 40.7 сая төгрөг байна.

**3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Могойн гол ХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТУЗ-ийн 2022 оны 2 дугаар сарын 22-ний өдрийн 04, 05 тоот тогтоолоор Могойн гол ХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан, 2022 оны 8 дугаар сарын 03-ны өдөр хуралдсан ТУЗ-ийн хурлаар бизнес төлөвлөгөөнд тодотгол хийж баталсан тогтоол нь Могойн гол компанийн ТУЗ-ын тэмдгээр баталгаажуагүй, тухайн хурлын тэмдэглэлгүй, эрх зүйн чадамжгүй ТУЗ-ийн гаргасан шийдвэр байна.

Гэтэл компанийн гүйцэтгэх удирдлага нь эрх зүйн чадамжгүй ТУЗ-ийн тодотгосон төсвийг баримтлан гүйцэтгэл гаргасан байна.

Тайлант онд мөрдсөн тодотгосон төлөвлөгөөгөөр нийт орлогыг 6,811.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 6,638.0 сая төгрөгөөр, 173.2 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна.

Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 3,671.1 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Хувьцаа Эзэмшигчдийн хурлын 2022 оны 04 дугаар сарын 29-ний өдрийн 02 дугаар тогтоолоор Могойн гол ХК-ийн 2022 оны ТУЗ-ийн зардлын төсвийг 202.5 сая төгрөгөөр тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 7,045.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 5,704.9 сая төгрөгийн зардал гарган, 1,359.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 7,045.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 233.8 сая төгрөг буюу 103.4 хувиар давж биелсэн нь тайлант онд коксжих нүүрсний борлуулалт 24,9 тн-оор давсан, борлуулах үнийг нэмсэн зэрэг хүчин зүйл нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 5,704.8 сая төгрөг буюу 85.9 хувийн гүйцэтгэлтэй гарч төлөвлөснөөс 933.2 сая төгрөг хэмнэсэн байна. Энэ нь борлуулалтын өртөг 920,3 сая төгрөгөөр буурсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 1,217.2 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 769,5 хувиар өссөн байна.

#### **3.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа**

2021 оны 5 дугаар сарын 21-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар бүрэн эрх нь баталгаажсан ТУЗ-ийн гишүүдийн хурал тайлант онд 5 удаа хуралдаж асуудлыг хэлэлцэж 21 тогтоол баталсан ч явцын дунд ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх асуудалд Төрийн төлөөлөл болон хувьцаа эзэмшигчдийн дунд маргаантай байдал үүссэн. Улмаар ТУЗ-ийн гишүүд 2 хуваагдаж маргаантай асуудал шүүхийн шатанд хянагдаж байгаа тул хоёр ТУЗ-ийг шийдвэр гаргах эрх зүйн чадамжтай гэж үзэх үндэслэлгүй байна.

ТУЗ-ийн 2022 оны зардалд 202.5 сая төгрөгийн төсөв батлагдаж 169.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнасан ч тайлант онд ТУЗ-ийн гишүүдийн хооронд үүссэн маргаантай холбоотой нийт 13 нэр бүхий ТУЗ-ийн гишүүд цалин, НДШ, шатахуун, хоол, буудал байрны зардлуудад 21.9 сая төгрөг хэтрүүлэн зарцуулсан бөгөөд сарын цалинг 0.8-1.0 сая төгрөгөөр тогтоосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 дах заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **4. Аудитын тайлан**

#### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Могойн гол ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨХБАҮХАТ хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэхээр өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Нью-баланс аудит ХХК-ний аудитор Д.Гэрэлчулуун гүйцэтгэж, хяналтыг Нью-баланс аудит ХХК-ийн партнер Б.Лхагвадорж анхан шатанд хянаж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатанд хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Могойн гол ХК нь 2022 оны санхүүгийн тайланг Нью-баланс аудит ХХК-д 2023 оны 02 дүгээр сарын 08-ний өдрийн 01/13 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Дотоод хяналт**

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Могойн гол ХК-ийн дотоод хяналт шалгалтын нэгжийг 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн захирлын А/09 дугаар тушаалаар 14 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмын хүрээнд үйл ажиллагаа явуулжээ. Тайланд онд 8 чиглэлээр 69 хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөн, хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар санхүү, нягтлан бодох бүртгэл, зардалтай холбоотой зөрчлийг илрүүлж зөвлөмж өгч ажилласан боловч, гүйцэтгэх удирдлага дотоод хяналтын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Могойн гол ХК нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 3,864.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 38.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 85 хувиар буюу 32.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3 заалтыг хянаж үзэхэд 3,119.0 сая төгрөгийн 38 худалдан авалтад гэрээ байгуулсан боловч 2,022.4 сард 24 гэрээний 535.8 сая төгрөгийн мэдээлэл оруулж 14 гэрээний 2,583.2 сая төгрөгийн худалдан авалтыг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зөвлөмж хүргүүлсэн.

#### 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомж, гэрээ хэлцлийн хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. Монгол Улсын "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн хэрэгжилтийг шалгахад ТУЗ-ийн гишүүдийн хооронд үүссэн маргаантай холбоотой нийт 13 нэр бүхий гишүүдэд 5,5 сарын цалинг илүү авч НДШ, шатахуун, хоол, буудал байрны зардлуудад 21.9 сая төгрөг хэтрүүлэн зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох"; 15.2.6 "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" заалтыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Уул уурхайн 100 жил, Могойн гол ХК-ийн 50 жилийн ой тэмдэглэх болон шинэ жилийн арга хэмжээний зардалд 88.9 сая төгрөг зарцуулж, компанийн хөрөнгийг үр ашиггүй зүйлд зарцуулсан байна. Энэ нь Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын ажлыг түр орлон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний 1 дүгээр зүйлийн 1.1,

2 дугаар зүйлийн 2.1.13 дах заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Хувь хүнээс худалдан авсан 17.2 сая төгрөгийн бараа материалын анхан шатны баримт дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн е-баримтаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дах заалтуудыг тус тус зөрчсөн ба Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Могойн гол ХК-ийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 58.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, 2 албан шаардлага өгснөөс 50.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт/сая. төгрөг/

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |          | Биелэлт |          | Зөрүү |     |         |
|-----------------|---------------------|----------|---------|----------|-------|-----|---------|
|                 | Тоо                 | Дүн      | Тоо     | Дүн      | Тоо   | Дүн | Хувь    |
| Зөвлөмж         | 2                   | 50,786.4 | 1       | 50,786.4 | 1     |     | 50 хувь |
| Албан шаардлага | 2                   | 7,334.1  | 1       | 7,334.1  | 1     |     | 50 хувь |
| Нийт дүн        | 4                   |          | 2       |          | 2     |     |         |

#### 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Могойн гол ХК-ийн санхүүгийн тайланд дараагийн аудитаар авч үзэх дараах асуудал байна. Үүнд:

- 2001-2009 онуудад үүссэн хугацаа хэтэрсэн 48.5 сая төгрөгийн найдваргүй авлага шийдвэрлэгдсэн эсэх
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 651.8 сая төгрөгийн хөрөнгийг Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 02 тоот тогтоолоор Орон нутгийн хувь нийлүүлсэн эх үүсвэрийг нэмэгдүүлэх шийдвэрийн талаар авсан арга хэмжээний талаар
- Дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй байгаа 5.7 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2001 онд баригдсан ажилчдын халуун усны барилга зэрэг асуудлыг анхаарах
- Гранд маннинг Экюпмент ХХК-д 2019 онд өрмийн машин авах гэрээ хийж урьдчилгаанд шилжсэн 70.0 сая төгрөгийн гүйцэтгэлийг дахин хянах

#### 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,429.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 193.6 сая төгрөгийн алдааг залруулж, 193.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 40.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,002.3 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

Үүнээс нийцэлтэй холбоотой 2,583.2 сая төгрөгийн 1 зөрчил илэрснээс 1 зөвлөмж өглөө.

##### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 193.6 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- Дөрвөн түшээ ХХК-тай гэрээгээр хийлгэсэн НБББББ-ийг 19.5 сая төгрөгийг зардлаар зөвшөөрч бүртгэсэн нь *Оршин байх* батламж мэдэгдлийг хангахгүй байх тул санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр бүртгүүлж залруулсан.
- Нүүрсний лабораторийн тоног төхөөрөмжийг хүлээн авч, худалдан авах гэрээний дагуу 62.3 сая төгрөгийн төлбөр бүрэн төлөгдсөн ч авлагаар бүртгэсэн алдааг залруулж хөрөнгөнд бүртгүүлсэн.

- Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэрийг 2 жилийн хугацаатай худалдан авах гэрээ хийж тайлант онд шилжүүлсэн 111.8 сая төгрөгийг авлагаар бүртгэсэн алдаг залруулж урьдчилж төлсөн зардалд бүртгүүлсэн.

## 8.2 Төлбөрийн акт

- ТУЗ-ийн гишүүдийн хооронд үүссэн маргаантай холбоотой нийт 13 нэр бүхий гишүүдэд 5,5 сарын цалинг илүү тооцон олгож, НДШ, шатахуун, хоол, буудал байрны зардлуудад 21.9 сая төгрөгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэн олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох"; 15.2.6 "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр ТҮАСИА ХХК-ийн нэрээр гэрээний нөхцөлд тусгаагүй түрээсийн төлбөрт 8.0 сая төгрөгийг Ц.Ариунболдын хувийн дансанд нотлох баримтгүйгээр шилжүүлэн "дуусаагүй үйлдвэрлэл" дансанд хаасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 1978-1992 онд улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын зардлын нөхөн төлбөр 344.2 сая төгрөгийг Урт хугацаат өр төлбөр дансанд бүртгэж, 2011-2015 он, 2016-2021 онуудад гэрээгээр жилд 1,000 \$ тухайн үеийн ханшаар тооцож улсад төлж байсан боловч 2022 онд гэрээгээ сунгаагүй, тайлант оны хашаар тооцсон 3.4 сая төгрөгийн нөхөн төлбөрийг төлөөгүй байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Байгууллагын данс бүртгэлд тусгагдаагүй хувь нэр дээрх эзэмшилтэй Ланд Ровэр /улсын дугаар 60-65/ машинд 7.3 сая төгрөгийн засвар хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1-т "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтыг тус тус зөрчиж, эрх ба үүрэг байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## 8.3 Албан шаардлага

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хойшилсон хурлуудаас ТУЗ-ын гишүүдийг сонгох асуудалд маргаан үүссэнээс 2 ТУЗ ажиллаж байгаа нь хувьцаа эзэмшигчдийн хурал бүрэн эрхээ хэрэгжүүлж чадаагүй бөгөөд Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт хэрэгжүүлж ажиллаагүй, мөн хуулийн 75 дугаар зүйлийн 75.6-д зааснаар ТУЗ нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадамжгүй байна. Энэ байдлаас харахад компанийн дээд удирдлагын үйл ажиллагаа доголдсон ба "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд нийт ажиллагсдад 13 дах сарын цалин 107.0 сая төгрөгийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр хавтгайруулан олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" заалтыг тус тус зөрчиж "Эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой" байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Авлагын дансны үлдэгдэл 86.2 сая төгрөгийн 77.9 хувь нь тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг

шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтыг хэрэгжүүлээгүй "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **8.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Анхан шатны баримттай холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:** Хувь хүнээс худалдан авсан 17.2 сая төгрөгийн бараа материалын анхан шатны баримт дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн е-баримтаар баталгаажуулж байна. Энэ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дах заалтуудыг тус тус зөрчсөн ба Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлд ажил гүйлгээг бүртгэхдээ борлуулагч талаас олгосон дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн е-баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэх.

##### **2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

**2.1 Илрүүлэлт:** Харилцах дансанд хийсэн сорилоор 86.0 сая төгрөгийн гүйлгээг шууд зардал дансанд бичсэн нь НББ-ийн тухай хуулийн 6 зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө" гэж заасныг зөрчсөн ба "Үнэн зөв байдал"-ын батламж мэдэгдлийг хангахгүй байна

**2.2 Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлд ажил гүйлгээг аккурэл сууриар бүртгэж тайлагнах

##### **3. Урьдчилан төлсөн зардал данстай холбоотой**

**3.1 Илрүүлэлт:** 2019 онд Гранд маннинг Экипмент ХХК-тай өрмийн машин авах гэрээ хийж урьдчилгаанд 70.0 сая төгрөг шилжүүлсэн боловч тодорхой шалтгааны улмаас хөрөнгөө авч чадаагүй асуудлыг шийдвэрлээгүй, 2022 онд ТУАСИА ХХК-тай тендер шалгаруулалт хийгээгүй, туршилтын гэрээ байгуулж урьдчилгаанд 157.0 сая төгрөг шилжүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.1-т "Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна" заалтыг зөрчсөн, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2 Өгсөн зөвлөмж:** Худалдан авах ажиллагааг хууль, журамд заасныг дагуу зохион байгуулж, байгууллагын дансанд дахь урьдчилж төлсөн зардлын авлагыг барагдуулах

##### **4. Хууль тогтоомж, гэрээ хэлцэлтэй холбоотой асуудал**

**4.1 Илрүүлэлт:** Уул уурхайн 100 жил, Могойн гол ХК-ийн 50 жилийн ой тэмдэглэх болон шинэ жилийн арга хэмжээний зардалд 88.9 сая төгрөг зарцуулж, компанийн хөрөнгийг үр ашиггүй зүйлд зарцуулсан байна. Энэ нь Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын ажлыг түр орлон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний 1 дүгээр зүйлийн 1.1, 2 дугаар зүйлийн 2.1.13 дах заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**4.2 Өгсөн зөвлөмж:** Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын ажлыг түр орлон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний заалтыг хэрэгжүүлж, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж ажиллах

**3.2 Илрүүлэлт:** Тайлант онд 3,119.0 сая төгрөгийн 38 худалдан авалтад гэрээ байгуулсан боловч 2022 оны 4 дүгээр сард 24 гэрээний 535.8 сая төгрөгийн мэдээлэл оруулж 14 гэрээний 2,583.2 сая төгрөгийн худалдан авалтыг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-

**Могойн гол ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

т “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан” заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3 заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

**5. Компанийн үйл ажиллагааг тогтмолжуулж, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой асуудал**

**5.1. Илрүүлэлт:**

Тайлант онд Нүүрсний лабораторийн тоног төхөөрөмж, Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр гэх мэт хөрөнгүүдийг гэрээгээр худалдан авсан, компанийн техник тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийгээгүй, тоног төхөөрөмж, машин механизмыг түрээсээр ажиллуулж байна.

**5.2. Өгсөн зөвлөмж:**

Цаашид хөрөнгө оруулалтын оновчтой аргыг сонгож мөнгөн урсгалыг сайжруулан, компанид хэрэгцээтэй хөрөнгө оруулалтыг хийж ажиллах

Дээрх акт ,албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

| Алдааны товч утга                   | Нийт алдаа |                  | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |                  | Үүнээс     |                  |              |     | Зөвлөмж |     |
|-------------------------------------|------------|------------------|-----------------------------------|-----|--------------------------|------------------|------------|------------------|--------------|-----|---------|-----|
|                                     |            |                  |                                   |     |                          |                  | Залруулсан |                  | Залруулаагүй |     |         |     |
|                                     | Тоо        | Дүн              | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн              | Тоо        | Дүн              | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| Зардалд бүртгэсэн                   | 1          | 19,500.0         |                                   |     | 1                        | 19,500.0         | 1          | 19,500.0         |              |     |         |     |
| Авлагаар бүртгэсэн                  | 1          | 62,270.0         |                                   |     | 1                        | 62,270.0         | 1          | 62,270.0         |              |     |         |     |
| Худалдан авалтыг авлагаар бүртгэсэн | 1          | 111,800.0        |                                   |     | 1                        | 111,800.0        | 1          | 111,800.0        |              |     |         |     |
| <b>Дүн</b>                          |            | <b>193,570.0</b> |                                   |     |                          | <b>193,570.0</b> |            | <b>193,570.0</b> |              |     |         |     |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

| Зөрчлийн товч утга                          | Нийт зөрчил |           | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |           | Зөвлөмж |          | Хариуцлага тооцуулах албан шаардлага |     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|---|-------------|-----------|---------------|----------|-----------------|-----------|---------|----------|--------------------------------------|-----|---|-----|
|   |             |           |               |          |                 |           |         |          | Тоо                                  | Дүн | Тоо   | Дүн |
|   | Тоо         | Дүн       | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн       | Тоо     | Дүн      | Тоо                                  | Дүн | Тоо   | Дүн |
| Төсөв хэтрүүлэн зарцуулсан                  | 2           | 128,990.3 | 1             | 21,966.5 | 1               | 107,023.8 |         |          |                                      |     |   |     |
| Е баримтаар нотлогдохгүй, татвар суутгаагүй | 2           | 17,255.0  |               |          |                 |           | 1       | 17,255.0 |                                      |     |   |     |

Могойн гол ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан


|  |           |                  |           |                 |          |                  |   |                  |          |
|--|-----------|------------------|-----------|-----------------|----------|------------------|---|------------------|----------|
| Анхан шатны баримтгүй хувь дансанд шилжсэн | 1         | 8,000.0          | 1         | 8,000.0         |          |                  |   |                  |          |
| Авлага баталгаажуу                         | 1         | 86,225.9         |           |                 | 1        | 86,225.9         |   |                  |          |
| Урт хугацаат өр төлбөр төлөгдөөгүй         | 1         | 3,400.0          | 1         | 3,400.0         |          |                  |   |                  |          |
| Түрээсийн гэрээгүй машинд зардал гаргасан  | 1         | 7,253.2          | 1         | 7,253.2         |          |                  |   |                  |          |
| Ойн арга хэмжээнд зардал гаргасан          | 1         | 88,973.6         |           |                 |          |                  | 1 | 88,973.6         |          |
| Харилцахаас зардал дансанд бичсэн          | 1         | 86,014.5         |           |                 |          |                  | 1 | 86,014.5         |          |
| УТЗ дансны үлдэгдэл                        | 1         | 227,000.0        |           |                 |          |                  | 2 | 227,000.0        |          |
| <b>Дүн</b>                                 | <b>00</b> | <b>653,112.5</b> | <b>00</b> | <b>40,619.7</b> | <b>2</b> | <b>193,249.7</b> |   | <b>419,243.1</b> | <b>0</b> |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |                    | Үүнээс        |     |                 |     |          |                    |
|---|-------------|--------------------|---------------|-----|-----------------|-----|----------|--------------------|
|   |             |                    | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж  |                    |
|   | Тоо         | Дүн                | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо      | Дүн                |
| <b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b> |             |                    |               |     |                 |     |          |                    |
| Мэдээлээгүй   | 1           | 2,583,242.5        |               |     |                 |     | 1        | 2,583,242.5        |
| <b>Бусад хууль тогтоомжтой холбоотой</b>                        |             |                    |               |     |                 |     |          |                    |
| ТУЗ-ын үйл ажиллагаатай холбоотой                               | 1           | 0.0                |               |     | 1               | 0.0 |          |                    |
| Үр ашигтай холбоотой  | 1           | 0.0                |               |     |                 |     | 1        | 0.0                |
| <b>Нийт дүн</b>   | <b>3</b>    | <b>2,583,242.5</b> |               |     | <b>1</b>        |     | <b>2</b> | <b>2,583,242.5</b> |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХ ШАТАНД ХЯНАСАН

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  Б.ТЭГШДЭЛГЭР

АХЛАХ АУДИТОР  Б.ДАВААНИЯМ

НЬЮ-БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН:

ЗАХИРАЛ  Б.ЛХАГВАДОРЖ

АХЛАХ АУДИТОР  Д.ГЭРЭЛЧУЛУУН